



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ӨЗБ (цаашид “Холбоо” гэх) нь Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Биржийн бус зах зээлд (цаашид “ББЗЗ” гэх)-ийн үнэт цаасны бүртгэл (цаашид “ББЗЗ”-ийн бүртгэл гэх)-д бүртгэх, үнэт цаас болон үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур, үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, үнэт цаас гаргагчаас мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмыг Холбооны Удирдах зөвлөл, Бүртгэлийн хороо, Холбооны Ажлын алба, Бүртгэлийн нэгж болон ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан Үнэт цаас гаргагч болон Шууд оролцогч, Үүргийн гүйцэтгэл хангуулагч, үнэт цаас гаргахтай холбоотой дүгнэлт гаргасан хөндлөнгийн этгээд дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт болон тэдгээрийг мөрдөж эхлэх хугацааг Удирдах зөвлөл батална.

2. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

- 2.1. ББЗЗ-ийн бүртгэлд үнэт цаас бүртгэхэд Холбоо, Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн мэргэжлийн байгууллагууд оролцоно. Үүнд:
 - 2.1.1. Удирдах зөвлөл;
 - 2.1.2. Бүртгэлийн хороо;
 - 2.1.3. Бүртгэлийн нэгж;
 - 2.1.4. Үнэт цаас гаргагч;
 - 2.1.5. Андеррайтер;
 - 2.1.6. Үүргийн гүйцэтгэл хангуулагч;
 - 2.1.7. Хөндлөнгийн этгээд;
 - 2.1.8. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага.

Удирдах зөвлөл

- 2.2. Удирдах зөвлөл нь ББЗЗ-тэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.2.1. ББЗЗ-ийн бүртгэл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдамж, зааврыг баталж, мөрдүүлж болно.
 - 2.2.2. “Биржийн бус зах зээлийн ерөнхий журам”-д заасны дагуу Бүртгэлийн хорооны гишүүнийг томилж, чөлөөлнө.
 - 2.2.3. Хүчин төгөлдөр журам, бусад зохицуулалтад тусгаагүй асуудлаар Биржийн бус зах зээлийн оролцогчдын хүсэлтийг хэлэлцэн зөвлөмж өгч болно.
 - 2.2.4. Энэ журамд заасны дагуу Бүртгэлийн хорооны шийдвэртэй холбоотой ирүүлсэн гомдол, хүсэлтийг хянана.
 - 2.2.5. Үнэт цаас гаргагчийг ББЗЗ-ийн бүртгэлийн шалгуураас чөлөөлж болно.



Бүртгэлийн хороо

- 2.3. Бүртгэлийн хороо нь үнэт цаасыг ББЗЗ-д бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг ил тод, бие даасан, шударга, хараат бус зарчмыг баримтлан гаргана.
- 2.4. Бүртгэлийн хороо нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 2.4.1. Бүртгэлийн хорооны орон тооны гишүүн;
 - 2.4.2. Бүртгэлийн хорооны орон тооны бус гишүүн.
- 2.5. Бүртгэлийн хорооны орон тооны гишүүн нь Удирдах зөвлөлийн гишүүн, Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга эсхүл Бүртгэлийн нэгжийн ажилтан байж болно.
- 2.6. Бүртгэлийн хорооны гишүүн нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - 2.6.1. “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 35.1-т заасан эрхтэй эсхүл Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 11.2-т заасан эрхийг авсан аудит, хөрөнгийн үнэлгээ болон хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн;
 - 2.6.2. Үнэт цаас зах зээл, банк санхүүгийн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
 - 2.6.3. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх.
- 2.7. Бүртгэлийн хороо нь нийт 5-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд үүнээс орон тооны гишүүд нь 2-оос дээшгүй байна.
- 2.8. Бүртгэлийн хорооны орон тооны болон орон тооны бус гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 хүртэл жил байна.
- 2.9. Бүртгэлийн хорооны орон тооны бус гишүүн нь 1 удаа 1 жилийн хугацаатай улиран сонгогдох эрхтэй. Томилогдсоноос хойш 3 жил тасралтгүй Бүртгэлийн хорооны гишүүнээр ажилласан тохиолдолд бүрэн эрх дуусгавар болсноос 2-оос доошгүй жилийн дараа дахин нэр дэвшиж болно.
- 2.10. Бүртгэлийн хороо нь энэ журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хэлбэр нь Бүртгэлийн хорооны хурал байна. Бүртгэлийн хорооны хурал нь Удирдах зөвлөлөөс баталсан Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны удирдамж, дэгийг дагаж мөрдөнө.
- 2.11. Бүртгэлийн хорооны гишүүнд олгох цалин, урамшууллын дүн, олгох хэлбэрийг Удирдах зөвлөл батална.

Бүртгэлийн нэгж

- 2.12. Бүртгэлийн нэгж нь ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн анхан шатны бүрдүүлэлтийг хянах, Бүртгэлийн хороонд үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг танилцуулах, Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээдээс ирүүлсэн мэдээ, мэдээллийг ББЗЗ-ийн цахим системээр дамжуулан оролцогчдод хүргэж ажиллана.
- 2.13. Бүртгэлийн нэгж нь Бүртгэлийн хорооны хурлын товыг зарлах, хуралд оролцох гишүүдэд холбогдох материалыг хүргэх, Үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээ, мэдээллийг тодруулахтай холбогдсон ажлыг зохион байгуулах үүрэгтэй.
- 2.14. Бүртгэлийн нэгж нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 2.14.1. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгүүд нь энэ журамд заасан шалгуурыг нотлох боломжтой, ирүүлбэл зохих баримт бичгийн бүрдэл хангана гэж үзсэн тохиолдолд Бүртгэлийн хороонд танилцуулах, шийдвэрлүүлэх;



- 2.14.2. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгүүд нь ББЗЗ-ийн бүртгэлийн шалгуурыг хангаагүй, анхан шатны баримт бичгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл хүсэлтийг буцаах;
- 2.14.3. Үнэт цаас гаргагчийн тогтмол хүлээх үүргийн хэрэгжилтийг хянаж, Удирдах зөвлөл, Бүртгэлийн хороонд мэдээлэх;
- 2.14.4. ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой асуудлаарх Бүртгэлийн хороо, Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах;
- 2.14.5. Бүртгэлийн хорооны хурлын тэмдэглэл хөтлөх, албажуулах, бүртгэх, хадгалах;
- 2.14.6. Бүртгэлийн хорооны шийдвэрийн төслийг бэлтгэх, шийдвэртэй холбоотой баримт бичгийг албажуулах, бүртгэх, хадгалах;
- 2.14.7. Бүртгэлийн нэгж нь бүртгэлийн хорооны хурлын шийдвэрийг холбогдох этгээдэд мэдээлэх.

Үнэт цаас гаргагч

- 2.15. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаанд энэ журмын 3-р бүлэгт заасан үнэт цаасны гарагчийн эрх бүхий этгээдтэй холбоотой шалгуур, 6-р бүлэгт заасан тогтмол хүлээх үүргийг хангаж ажиллана.
- 2.16. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журам болон ББЗЗ-д үнэт цаас бүртгүүлэхтэй холбогдуулан батлагдсан зааврын дагуу хүсэлтээ гаргах үүрэгтэй.
- 2.17. ББЗЗ-ийн бүртгэлд үнэт цаас нь бүртгэгдсэн тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргатай Үнэт цаасны бүртгэлийн гэрээ байгуулж, тухайн Үнэт цаас гаргагч нь гэрээний хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

Андеррайтер

- 2.18. Андеррайтер нь СЗХ-оос холбогдох тусгай зөвшөөрлийг авсан, ББЗЗ-ийн шууд оролцогч байна.
- 2.19. Андеррайтер нь ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.19.1. Үнэт цаас гаргагчийн ББЗЗ-д бүртгүүлэх хүсэлт, хавсаргах баримт бичиг, Төслийн танилцуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэх;
 - 2.19.2. Энэ журмын хавсралт 2-т заасан мэдэгдлийг ирүүлэхдээ судалгаа шинжилгээ хийх ба эх сурвалж, үр дүнгийн мэдээлэл нь үнэн зөв, тухайн үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хамааралтай мэдээллийг эерэг сөрөг талаас бүрэн илэрхийлсэн байх;
 - 2.19.3. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг ББЗЗ-д бүртгэхэд Бүртгэлийн нэгжээс тавьсан шаардлагыг тухай бүр биелүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;
 - 2.19.4. Энэ журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийг төлөөлөн Бүртгэлийн хорооны хуралд оролцох, шаардлагатай мэдээлэл, тодруулгыг өгөх;
 - 2.19.5. Бүртгүүлсэн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах;
 - 2.19.6. Төслийн танилцуулгад тусгасан үйл ажиллагаа, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 2.19.7. Харилцагчийг таньж мэдэх, үүнтэй холбоотой хууль, журмыг хэрэгжүүлэх;
 - 2.19.8. Үнэт цаасны өгөөж, эрсдэлийн хэмжээ, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаар үнэн зөв, бүрэн мэдээллийг харилцагчид мэдүүлэх;

- 2.19.9. Энэ журмын 6-р бүлэгтэй холбоотой үүргийг үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, энэ журмын хавсралт 7-т заасан тайланг улирал бүр ирүүлэх.
- 2.19.10. Үнэт цаас гаргагчтай тохиролцож, холбогдох гэрээг байгуулсан тохиолдолд түүний Үүргийн гүйцэтгэл хангуулагчаар ажиллаж болно.
- 2.20. Андеррайтер нь Бүртгэлийн нэгжид ирүүлсэн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгээс агуулгын хувьд зөрүүтэй мэдээллийг ББЗЗ-ийн оролцогчид танилцуулахыг хориглоно.

Үүргийн гүйцэтгэл хангуулагч

- 2.21. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь ББЗЗ-д бүртгэгдэх Үнэт цаасны барьцаа, баталгаа, батлан даалтыг гэрчилж, үнэт цаасны төлбөртэй холбоотой аливаа эрсдэл үүссэн тохиолдолд хөрөнгө оруулагчийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй дараах оролцогч байна. Үүнд:
- 2.21.1. Өрийн хэрэгслийн хувьд андеррайтер эсхүл үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн фирм;
- 2.22. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.22.1. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй үнэт цаас нь барьцаа, баталгаа, батлан даалттай байх тохиолдолд эдгээр нь үнэт цаасны төлбөрийн эрсдэлийг хаах боломжтой эсэхэд дүгнэлт өгөх;
- 2.22.2. Үнэт цаас гаргагч нь барьцаа, баталгаа, батлан даалттай үнэт цаас гаргаж байгаа нөхцөлд тэдгээрийг хөрөнгө оруулагчийн өмнөөс өөрийн нэр дээр барьцаалах, барьцаа, баталгаа, батлан даалтыг хэрэгжүүлэх нөхцөл үүссэн бол үнэт цаас эзэмшигчдийн хохирлыг барьцаа болон баталгаа, батлан даалтаар барагдуулах ажлыг зохион байгуулах;
- 2.22.3. Үнэт цаас гаргагчаас тогтмол ирүүлэх мэдээллийг хүлээн авч, үнэн зөвийг нягтлах, ББЗЗ-ийн мэргэжлийн оролцогчдод тэдгээр мэдээллийг заасан хугацаанд хүргэх;
- 2.22.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, ирүүлж буй мэдээ, мэдээлэл, барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтөд тогтмол хяналт тавих, шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчид барьцаа нэмэгдүүлэх шаардлага тавих;
- 2.22.5. Энэ журмын 6-р бүлэгтэй холбоотой үүргийг үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, энэ журмын хавсралт 7-т заасан тайланг улирал бүр ирүүлэх.

Хөндлөнгийн этгээд

- 2.23. Хөндлөнгийн этгээд нь СЗХ-нд бүртгэлтэй хууль болон хөрөнгийн үнэлгээний компани байна.
- 2.24. Хөндлөнгийн этгээд нь үнэт цаас гаргагчийн Төслийн танилцуулга, үйл ажиллагаатай холбоотой аливаа хуулийн эсхүл хөрөнгийн үнэлгээ хийсэн этгээд байна.
- 2.25. Хөндлөнгийн этгээд нь өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг бүрэн хариуцна.
- 2.26. Үүргийн гүйцэтгэл хангуулагч шаардсан тохиолдолд үнэт цаасыг бүртгэснээс хойш тодорхой хугацаанд Үнэт цаас гаргагчийн засаглалыг сайжруулах, хууль тогтоомж, бүртгэлийн болон тогтмол хүлээх үүргийг хангуулах чиглэлээр түүнд аудитын болон хуулийн үйлчилгээ үзүүлсэн этгээд нь үргэлжлүүлэн зохих үйлчилгээ үзүүлж болно.



3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ШАЛГУУР

Үнэт цаас гаргагчийн ерөнхий шалгуур

- 3.1. ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэгдэх Үнэт цаас гаргагч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 3.1.1. Хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
 - 3.1.2. Хүсэлт гаргахаас өмнө 1-ээс доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
 - 3.1.3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийн зарцуулалт тодорхой байх;
 - 3.1.4. Санхүүгийн тайлан сүүлийн 1 жилийн хугацаанд аудитлагдсан байх;

Хаалттай хүрээнд хувьцаагаа санал болгож буй үнэт цаас гаргагчид тавигдах тусгай шалгуур

- 3.2. Хаалттай хүрээнд энгийн болон давуу эрхийн хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож буй хаалттай хувьцаат компани нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 3.2.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлсэн байх;
 - 3.2.2. Хөрөнгө оруулагч нь тодорхой болоогүй бол андеррайтертэй гэрээ байгуулсан байх;
- 3.3. СЗХ-ны холбогдох журамд заасны дагуу Гарааны компани нь ББЗЗ-ийн бүртгэлд бүртгүүлэн хувьцаагаа мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох тохиолдолд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 3.3.1. СЗХ-ны холбогдох журамд заасан Гарааны компанид тавигдах шалгуур, шаардлагыг хангасан байх;
 - 3.3.2. Хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох зорилгоор андеррайтертэй гэрээ байгуулсан.

Хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргаж буй үнэт цаас гаргагчид тавигдах тусгай шалгуур

- 3.4. ББЗЗ-ийн бүртгэлд өрийн хэрэгсэл бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан ерөнхий шалгуураас гадна дараах нэмэлт шалгуурыг хангана. Үүнд:
- 3.4.1. Өрийн хэрэгсэл нь хөрөнгө оруулагчид төлөх шаардлагатай нийт үнийн дүнгээс багагүй хэмжээний барьцаа, батлан даалт, баталгаатай байх ба эсхүл СЗХ-оос холбогдох зөвшөөрөл авсан этгээдээр санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон байх;
 - 3.4.2. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах төлөвлөгөөтэй байх;
 - 3.4.3. Үнэт цаас гаргагчид баталгаа гаргаж буй этгээд нь гуравдагч этгээдэд ижил төрлийн баталгаа гаргаагүй байх ба гуравдагч этгээд ижил төрлийн баталгаа гаргаж өгсөн бол тэргүүн ээлжид Үнэт цаас гаргагчийн гаргасан өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гэрээ байгуулсан байх;
 - 3.4.4. Өрийн хэрэгслийн барьцаа, батлан даалт, баталгаа нь зээл, түрээс болон санхүүгийн түрээсийн гэрээ, өрийн бичгээс үүсэх шаардах эрх гэх мэт ирээдүйд мөнгөн урсгал бий болгох боломжтой санхүүгийн хэрэгслээс бүрдээгүй байх;
 - 3.4.5. Өрийн хэрэгсэл хөтөлбөртэй бонд бол хөтөлбөрийн нийт хугацаа 18 сараас багагүй байх;

- 3.4.6. Үнэт цаас гаргагч ногоон бонд гаргах бол Монгол Улсын “Ногоон таксономи”, эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” үйл ажиллагаа эрхэлдэг байх, СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 5 дугаар бүлэгт заасан нөхцөл шаардлагыг хангаж байх; (олон улс, эсхүл дотоодын хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагаар дүгнэлт гаргуулж болно)
 - 3.4.7. Өрийн хэрэгсэл гаргаж буй этгээд нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж болно. Энэ тохиолдолд батлан даах хувьцаа нь үнэт цаас гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байх.
 - 3.4.8. Өрийн хэрэгслийг худалдан авах хөрөнгө оруулагч нь тодорхой болоогүй бол Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай гэрээ байгуулсан байх;
 - 3.4.9. Өрийн хэрэгслийн барьцаа, баталгаа, батлан даалтыг хөрөнгө оруулагч тус бүрээр хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангуулагчтай гэрээ байгуулсан байх;
 - 3.4.10. Андеррайтер эсхүл үүргийн гүйцэтгэл хангуулагчтай гэрээ байгуулах шаардлагагүй бол өрийн хэрэгслийг худалдах, худалдан авах гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах харилцааг тусгасан байна.
- 3.5. Үнэт цаас гаргагчийн өмнөөс баталгаа гаргаж буй этгээд нь хуулийн этгээд бол энэ журмын 3-р бүлэгт заасан ерөнхий шалгуурыг, хувь хүн бол түүний хөрөнгө нь тухайн үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой байна.

Хаалттай хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж буй үнэт цаас гаргагчийн тусгай шалгуур

- 3.6. ББЗЗ-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бол дараах тусгай шалгуурыг хангана. Үүнд:
- 3.6.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байх;
 - 3.6.2. СЗХ-оос зөвшөөрөл авсан тусгай зориулалтын компани байх;
 - 3.6.3. Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулсан байх;

4. ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

Үнэт цаас гаргагч хүсэлт гаргах

- 4.1. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-д үнэт цаасыг анх удаа болон нэмж гаргах хүсэлт ирүүлэхдээ дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
- 4.1.1. Албан хүсэлт (“Үнэт цаас гаргах тухай” эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргах)
 - 4.1.2. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл (Маягт №2001);
 - 4.1.3. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт №2002);
 - 4.1.4. Андеррайтертай хамтран ажиллах тохиолдолд түүний мэдэгдэл (Маягт №2003), дүгнэлт;
 - 4.1.5. Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай хамтран ажиллах тохиолдолд түүний мэдэгдэл (Маягт №2004);
 - 4.1.6. Төслийн танилцуулга;

- 4.2. Төслийн танилцуулгыг Удирдах зөвлөлөөс баталсан зааврын дагуу бэлтгэсэн байна.
- 4.3. Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд байх нөхцөлд хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргуулна.
- 4.4. Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв, алдаагүй, зөрүүтэй утга агуулга илэрхийлээгүй, Бүртгэлийн хороо шийдвэрээ гаргах болон мэргэжлийн оролцогчид хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай мэдээллийг тусгасан байна. Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг Үнэт цаас гаргагч хариуцна.

Үнэт цаас бүртгүүлэх төслийн танилцуулга ирүүлэхээс чөлөөлөгдөх

- 4.5. Бүртгэлийн хороо дараах Үнэт цаас гаргагчаас Төслийн танилцуулгыг шаардахгүй байж болно. Үүнд:
 - 4.5.1. Үнэт цаас гаргагч нь Засгийн газар эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсын Хөгжлийн банк бол;
 - 4.5.2. Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, тайлагналын болон засаглалын шаардлагыг бүрэн хангаж байгаа, СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагаас зөрчил арилгах тухай даалгавар, шийдвэр аваагүй хуулийн этгээд бол;
 - 4.5.3. Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг худалдан авах хөрөнгө оруулагч нь тодорхой бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тухайн үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан.

5. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх

- 5.1. Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг дараах үе шаттайгаар хянаж ББЗЗ-д бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. Үүнд:
 - 5.1.1. Үнэт цаас гаргах хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авах, хянах;
 - 5.1.2. Үнэт цаас гаргах хүсэлтийг Бүртгэлийн хороогоор хэлэлцэж, шийдвэр гаргах.
- 5.2. Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн хүсэлтийг Бүртгэлийн нэгж хүлээн авч, анхан шатны хяналтыг хийнэ. Үүнд:
 - 5.2.1. СЗХ болон Холбооны холбогдох журамд заасан ББЗЗ-д үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой шалгуур, шаардлагыг хангаж буй эсэх;
 - 5.2.2. Бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг бүрэн эсэх;
 - 5.2.3. Бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичигт заасан аливаа мэдээ, мэдээлэл зөрүүтэй, илт төөрөгдөл үүсэхүйц мэдээлэл агуулж байгаа эсэх;
 - 5.2.4. Хүсэлтэд хавсаргавал зохих баримт бичгийн бүрдэл хангагдсан эсэх;
 - 5.2.5. Ирүүлсэн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг үдэж, хавтаслан, товьёг хийсэн эсэх.

- 5.3. Бүртгэлийн нэгж Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг ажлын 3 өдрийн дотор хянаж, нэмэлт ажиллагаа шаардлагагүй, эсхүл уг ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн гэж үзвэл Хавсралт 5-д заасан “Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг шалгах хяналтын хуудас”-ыг үнэн зөв бөглөн, Үнэт цаас гаргагчийн талаар танилцуулга, дүгнэлт бэлтгэж, үнэт цаасыг бүртгэх эсэхийг шийдвэрлүүлэхээр Бүртгэлийн хорооны хуралд оролцох гишүүдэд үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хүргүүлнэ.
- 5.4. Шаардлагатай тохиолдолд Бүртгэлийн нэгж нь нэмэлт мэдээлэл, тодруулгыг Үнэт цаас гаргагчаас шаардаж болно. Энэ тохиолдолд нэмэлт материал шаардсан үндэслэл, шалтгааныг хүсэлт ирүүлсэн этгээдэд тайлбарлах үүрэгтэй.

Бүртгэлийн хорооны хурлыг зохион байгуулах

- 5.5. Бүртгэлийн нэгж нь Бүртгэлийн хорооны хурлын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна. Бүртгэлийн нэгж нь ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө Бүртгэлийн хорооны нийт гишүүдэд хурлын зар болон хэлэлцэх асуудалд холбогдох хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хүргүүлнэ.
- 5.6. Бүртгэлийн хорооны ээлжит хурлын товыг холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга батлах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлаж болно.
- 5.7. Бүртгэлийн хорооны хурлыг Бүртгэлийн хорооны орон тооны гишүүн даргална.
- 5.8. Бүртгэлийн хорооны гишүүн нь сонирхлын зөрчил үүсч болзошгүй болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ тухайгаа нэн даруй Бүртгэлийн нэгжид мэдэгдэх үүрэгтэй.
- 5.9. Бүртгэлийн нэгж нь Бүртгэлийн хорооны гишүүд Үнэт цаас гаргагчтай ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй гэж үзвэл талуудаас тодруулга авах, Бүртгэлийн хорооны гишүүнийг тус хүсэлтийг шийдвэрлэх хуралд оролцуулахгүй байх эрхтэй.
- 5.10. Бүртгэлийн хорооны гишүүн нь өмнө нь танилцуулагдсан хүсэлтийг хэлэлцэх хуралд орох бол тухайн хүсэлтийг өмнө нь хэлэлцсэн хурлуудын тэмдэглэлтэй бүрэн танилцсан байна.
- 5.11. Бүртгэлийн хороо үнэт цаасыг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр гаргахаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийг төлөөлж буй Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагчийг хуралд оролцуулж шийдвэрийн үндэслэлийг тодорхой танилцуулна.
- 5.12. Үнэт цаас гаргагчийн Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь Бүртгэлийн хорооны үнэт цаас бүртгэх эсэх асуудлаар давтан хэлэлцэж буй хуралд Бүртгэлийн нэгжид хүсэлт гарган оролцох эрхтэй.
- 5.13. Энэ журмын 5.11, 5.12-д заасан харилцааг энэ журмын 2.2.1-д заасан зохицуулалтад тусгана.

Бүртгэлийн хороо үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх

- 5.14. Бүртгэлийн хорооны хурлаар Үнэт цаас гаргагчийн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг Бүртгэлийн нэгжээс хүлээн авч, энэ журамд заасан үнэт цаас гаргагчийн ерөнхий болон тусгай шалгуурыг хангаж буй эсэх, хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл, агуулгыг тус тус хянаж, шийдвэрлэнэ.
- 5.15. Бүртгэлийн хороо 3-аас доошгүй гишүүний ирцтэйгээр хуралдана.
- 5.16. Бүртгэлийн хорооны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 5.17. Бүртгэлийн хорооны тогтоолын төслийг Бүртгэлийн нэгж бэлтгэж Бүртгэлийн хороонд танилцуулна.

- 5.18. Бүртгэлийн хороо Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хянаж дараах шийдвэрийг гаргана. Үүнд:
- 5.18.1. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах;
 - 5.18.2. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэхээс татгалзах;
 - 5.18.3. Үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлээс хасах;
 - 5.18.4. Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг Бүртгэлийн нэгжид буцаах, дахин хэлэлцэх, энэ тохиолдолд шийдвэрийг хурлын тэмдэглэлд тусгана.
- 5.19. Бүртгэлийн хороо энэ журамд заасан шийдвэр гаргахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 5.19.1. СЗХ болон Холбооны холбогдох журамд заасан ББЗЗ-д үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой шалгуур, шаардлагыг хангуулах;
 - 5.19.2. Барьцаа, батлан даалт, баталгаа бүхий үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангуулах болон хөрөнгө оруулагчийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөөг тодорхой байлгах;
 - 5.19.3. СЗХ-ны зохицуулалттай этгээдийн дүгнэлт, тооцоолол, тайланд үнэлэлт, дүгнэлт өгөхгүй байх;
 - 5.19.4. Бүртгэлийн хорооны гишүүн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тодорхой зөвлөмж, тайлбарыг үнэт цаасны бүртгэлийн холбогдох шийдвэрт хавсаргах;
 - 5.19.5. Хэлэлцэх асуудлын танилцуулга, хүсэлтэд тусгасан аливаа мэдээ, мэдээлэл зөрүүтэй, илт төөрөгдөл үүсэхүйц утга агуулсан бол асуудлыг хэлэлцэхээс татгалзах;
 - 5.19.6. ББЗЗ-тэй холбоотой аливаа зохицуулалтад тусгаагүй шаардлага, шалгуурыг хүсэлт гаргагчаас шаардахгүй байх.
- 5.20. Бүртгэлийн хорооны шийдвэрт үнэт цаасыг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулахаас татгалзсан, бүртгэлээс хассан, дахин хэлэлцэхээр хойшлуулсан тохиолдолд шийдвэрийн үндэслэлийг тодорхой тусгана.

Үнэт цаасыг бүртгэх шийдвэр гаргах

- 5.21. Үнэт цаас гаргагч болон түүний санал болгох үнэт цаас нь ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэгдэх шалгуур, баримт бичгийн шаардлагыг бүрэн хангаж байгаа нөхцөлд Бүртгэлийн хороо нь үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэх шийдвэрийг гаргана.
- 5.22. Бүртгэлийн хорооны шийдвэрт дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 5.22.1. Бүртгүүлж буй үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл;
 - 5.22.2. Үнэт цаасны нөхцөл (Бүх төрлийн өрийн хэрэгслийн транчийн мэдээлэл хамаарахгүй);
 - 5.22.3. Энэ журамд заасны дагуу Бүртгэлийн хорооноос гаргасан санал, зөвлөмж, хязгаарлалт;
 - 5.22.4. Бүртгэлийн хорооны шаардлагатай гэж үзсэн бусад.

Үнэт цаас гаргах тухай асуудлыг дахин хэлэлцэхээр хойшлуулах, дахин хэлэлцэх

- 5.23. Бүртгэлийн хороо үнэт цаас бүртгүүлэх асуудлыг нэг удаа хойшлуулж болно.
- 5.24. Бүртгэлийн хороо дараах тохиолдолд үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг Бүртгэлийн нэгжид дахин хянуулахаар буцааж болно. Үүнд:

- 5.24.1. Бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг нотлох зорилгоор нэмэлт материал шаардлагатай бөгөөд уг нэмэлт баримт бичгийг ажлын 15 өдрийн дотор бүрдүүлэх боломжтой, үүнийг андеррайтер эсхүл үүргийн гүйцэтгэл хангуулагч нь мэдэгдсэн;
- 5.24.2. Бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь техникийн шинжтэй алдаатай, зөрүүтэй мэдээлэл агуулсан бөгөөд ажлын 10 өдрийн дотор залруулах боломжтой, үүнийг андеррайтер эсхүл үүргийн гүйцэтгэл хангуулагч нь мэдэгдсэн;
- 5.24.3. Хэлэлцэх асуудалтай холбоотой Удирдах зөвлөлөөс чиглэл авах шаардлагатай гэж Бүртгэлийн хороо үзсэн.
- 5.25. Бүртгэлийн хороо Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг Бүртгэлийн нэгжид дахин хянуулахаар буцаасан тохиолдолд Бүртгэлийн нэгж Бүртгэлийн хорооны өгсөн үүрэг даалгаврын дагуу Үнэт цаас гаргагчийн хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг шаардлагад нийцүүлсний дараагаар дахин 1 удаа Бүртгэлийн хорооны хурлаар хэлэлцүүлж болно.
- 5.26. Бүртгэлийн хороо нь энэ журмын 5.25-т заасан асуудлаар дахин хуралдах тохиолдолд өмнөх хурлаар хэлэлцсэн асуудлаар хуралдаж шийдвэр гаргана. Өмнөх хурлаар хүсэлтийг буцаасан үндэслэлээс бусад үндэслэлээр үнэт цаас бүртгэхээс татгалзах, буцаах шийдвэр гаргахгүй.

Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах

- 5.27. Бүртгэлийн хорооны хурлаар дараах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 5.27.1. Бүртгэлийн хороо нь үнэт цаас гаргагч, түүний санал болгож буй үнэт цаасыг энэ журамд заасан үнэт цаасыг ББЗЗ-д бүртгэх зарчимд нийцээгүй, шалгуурыг хангаагүй гэж үзсэн
- 5.27.2. Хүсэлтийг дахин хэлэлцэх хуралд Бүртгэлийн хорооноос шаардсан баримт бичгийг ирүүлээгүй, ирүүлсэн материал нь энэ журам, холбогдох баримт бичигт заасан шаардлага хангаагүй;
- 5.27.3. Хүсэлтийг дахин хэлэлцэх хуралд Бүртгэлийн хорооноос шаардсан засварыг хийгээгүй, хийхээс татгалзсан;
- 5.27.4. Удирдах зөвлөлөөс чиглэл, зөвлөмж ирүүлсэн (энэ тохиолдолд Бүртгэлийн хороо Удирдах зөвлөлөөс чиглэл хүссэн байна).
- 5.28. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг Үнэт цаас гаргагчид албан бичгээр хүргүүлэх ба үүнд татгалзсан үндэслэлийг тусгасан байна. Тус шийдвэрт заасан үндэслэл нь энэ журамд заасан Үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур, шаардлагын хүрээнд байна.
- 5.29. Үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай Бүртгэлийн хорооны шийдвэрийг Үнэт цаас гаргагч эс зөвшөөрвөл Удирдах зөвлөлд шийдвэр хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор уг шийдвэртэй холбоотой гомдол гаргах эрхтэй.

Бүртгэлийн шалгуураас чөлөөлөх

- 5.30. Үнэт цаас гаргагч, түүний хамтран ажиллаж буй Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнө эсхүл хамтад нь энэ журамд заасанд чөлөөлөгдөх үнэсдлэлээс бусад үндэслэлээр чөлөөлөгдөх тухай хүсэлтээ Удирдах зөвлөлд гаргах эрхтэй.
- 5.31. Удирдах зөвлөл нь энэ журмын 5.30-д заасан хүсэлтийг хүлээн авч ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагчаас гаргаж буй баталгаа, өгсөн дүгнэлт, үнэт цаас гаргахтай холбоотой хийж гүйцэтгэсэн аливаа дүн шинжилгээ зэрэгтэй танилцаж болно.

- 5.32. Бүртгэлийн хороо дараах Үнэт цаас гаргагчийг энэ журмын 3-р бүлэгт заасан шалгуураас хэсэгчлэн чөлөөлж болох ба энэ тохиолдолд Бүртгэлийн хорооны шийдвэрт нэмэлт санал, зөвлөмж, хязгаарлалтыг хавсаргаж болно. Үүнд:
- 5.32.1. Үнэт цаас гаргагч нь Засгийн газар эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсын Хөгжлийн банк бол;
 - 5.32.2. Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, тайлагналын болон засаглалын шаардлагыг бүрэн хангаж байгаа, СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагаас зөрчил арилгах тухай даалгавар, шийдвэр аваагүй хуулийн этгээд бол;
 - 5.32.3. Тодорхой хугацааны дараа бүртгэлийн шалгуурыг бүрэн хангах боломжтой, энэ тухай тодорхой төлөвлөгөө, нотолгоо ирүүлсэн бол;
 - 5.32.4. Монгол улсын тэргүүлэх чиглэл (Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын баримт бичигт тодорхойлсон)-д багтаж буй салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бол;
 - 5.32.5. СЗХ-оос ББЗЗ-д үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн Үнэт цаас гаргагч бол;
 - 5.32.6. Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг худалдан авах хөрөнгө оруулагч нь тодорхой бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тухайн үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан;
 - 5.32.7. Монгол Улсын “Ногоон таксономи”, эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” үйл ажиллагааг санхүүжүүлэх бол.
- 5.33. Бүртгэлийн хороо нь ББЗЗ-д үнэт цаас гаргагчийг дараах шалгуураас чөлөөлж болно. Үүнд:
- 5.33.1. СЗХ-ны шалгуурыг хангасан гарааны компани, тусгай зориулалттай компани бол энэ журамд заасан үүсгэн байгуулагдсанаас хойш үйл ажиллагаа явуулсан байх хугацааны шалгуураас;
 - 5.33.2. Энэ журамд заасан шалгуурыг бүрэн хангасан баталгаа гаргагч бүхий үнэт цаас гаргагчийг энэ журамд заасан хугацааны шалгуураас;
 - 5.33.3. Удирдах зөвлөлийн энэ журмын 5.30-д заасан шийдвэрт заасан шалгуураас тус тус чөлөөлнө.

Үнэт цаасны самбар

- 5.34. ББЗЗ-д үнэт цаасыг үнэт цаас гаргагчийн төрлөөс хамаарсан үндсэн 3 самбарт үнэт цаасны төрөл бүрээр бүртгэнэ. Үүнд:
- 5.34.1. “А” самбарт: Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсын Хөгжлийн банк;
 - 5.34.2. “В” самбарт ББЗЗ-ийн ерөнхий болон үнэт цаасны нарийвчилсан шаардлагыг бүрэн хангасан үнэт цаасыг;
 - 5.34.3. “С” самбарт: Дараах тохиолдлын аль нэгт хамаарах үнэт цаасыг:
 - 5.34.3.1. СЗХ-ны журам болон энэ журамд заасан гарааны бизнес эрхлэгчийн гаргасан үнэт цаас бол;
 - 5.34.3.2. Бүртгэлийн хорооноос бүртгэлийн шаардлага хангахтай холбоотой тодорхой хугацаатай үүрэг, даалгавар өгсөн эсхүл тодорхой нөхцөлтэйгөөр бүртгэсэн;



5.34.3.3. Урьдчилан тохирсон 5-аас доош хөрөнгө оруулагчдад үнэт цаас эзэмшүүлэхээр тохирсон бөгөөд хөрөнгө оруулагчид үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан.

5.35. ББЗЗ-д үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэрт үнэт цаасны хамаарах самбарыг заах ба тухай үнэт цаас бусад самбарт хамаарах нөхцөл бүрдсэн тохиолдолд Бүртгэлийн хороо бүртгэлийн нэгжийн хүсэлтийг үндэслэн самбар шилжүүлэх эсэх шийдвэр гаргана.

Үнэт цаасанд үсгэн код, нэр олгох

- 5.36. Бүртгэлийн нэгж нь Бүртгэлийн хорооны шийдвэр, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан үнэт цаасанд үсгэн код, үнэт цаасны нэр олгон бүртгэх ба Үнэт цаас гаргагчтай хавсралт 9-т заасан "Үнэт цаасны бүртгэлийн гэрээ" байгуулан үнэт цаас бүртгэсэн тухай мэдээллийг холбогдох хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.
- 5.37. Үнэт цаасны үсгэн код нь үнэт цаасны нэрийг илэрхийлэх 4 тэмдэгт (латин үсэг)-ээр тэмдэглэгдэнэ.
- 5.38. Үнэт цаасны код, нэрийг давхардуулахгүй олгоно.
- 5.39. Өрийн хэрэгслийг үнэт цаасны нэрээр бүртгэх ба нэрэнд өрийн хэрэгслийн хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөгдөх хугацаа зэргийг тусгана. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийг транчтай гаргах тохиолдолд транч тус бүрийг ялгах тэмдэглэгээ хийнэ.

Үнэт цаасыг танилцуулах, мэдээлэх

- 5.40. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-д бүртгэгдсэн үнэт цаасны талаарх мэдээллийг дараах хэлбэрээр түгээж болно. Үүнд:
- 5.40.1. Холбооны ББЗЗ-ийн цахим систем;
- 5.40.2. Андеррайтер эсхүл үүргийн гүйцэтгэл хангуулагчийн санал болгосон аливаа мэдээллийн хэрэгсэл.
- 5.41. ББЗЗ-д хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй үнэт цаасны зар сурталчилгааг Бүртгэлийн хорооны шийдвэр гарахаас өмнө нийтийн сүлжээнд түгээхийг хориглоно.
- 5.42. ББЗЗ-д хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй үнэт цаасны зар сурталчилгааг нийтийн сүлжээнд байршуулах бол дараах утгыг агуулаагүй байна. Үүнд:
- 5.42.1. Үнэт цаас гаргагчийн болон үнэт цаасны нэр, код, лого болон тэдгээрийг илэрхийлэх агуулга бүхий мэдээлэл;
- 5.42.2. Төслийн танилцуулгад тусгаснаас ялгаатай буюу зөрүүтэй мэдээлэл.

6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТМОЛ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагчийн үүрэг

- 6.1. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-д бүртгэлтэй байх хугацаанд Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааварт туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.
- 6.2. ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаанд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 6.2.1. Энэ журамд заасан шалгуурыг тогтмол хангаж ажиллах;
- 6.2.2. Бүртгэлийн нэгжтэй байгуулсан Үнэт цаасны бүртгэлийн гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлэх;

- 6.2.3. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаар, үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх мэдээллийг холбогдох хууль болон аудитын байгууллагаар баталгаажуулан ББЗЗ-ийн оролцогчдод хүргүүлэх;
- 6.2.4. Бүртгэлийн нэгж, Андеррайтер, Үүргийн гүйцэтгэл хангуулагч, үнэт цаас эзэмшигчдээс гаргасан үнэт цаас болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээ, мэдээлэл тодруулга хүссэн бол түүнийг тухай бүр ирүүлэх.
- 6.3. Үнэт цаас гаргагч, түүнтэй гэрээ бүхий үнэт цаасны компани нь Бүртгэлийн хорооны шийдвэрийг хөрөнгө оруулагчид танилцуулах үүрэгтэй.

Тогтмол мэдээлэх үүрэг

- 6.4. ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаанд дараах мэдээллийг тогтмол хугацаанд ирүүлнэ. Үүнд:
- 6.4.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан санхүүгийн тайланг дараах хугацаанд:
- 6.4.1.1. эхний хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ний дотор
- 6.4.1.2. жилийн эцсийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 10-ний дотор
- 6.4.2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан болон үнэт цаасны хүү, эргэн төлөлтийн тайланг улирал тутам гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.


Тухай бүр мэдээлэх үүрэг

- 6.5. Үнэт цаас гаргагч нь дараах мэдээллийг тухай бүр үйл явдал болсноос хойш ажлын 2 өдөрт багтаан ББЗЗ-ийн оролцогчдод мэдээлнэ. Үүнд:
- 6.5.1. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл (Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэг) байгуулсан эсхүл тухайн төрлийн гэрээ, хэлцэл байгуулах гэж байгаа тухай мэдээлэл;
- 6.5.2. Үнэт цаас гаргагчийн барьцаа хөрөнгө эсхүл үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 30 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлсэн, битүүмжилсэн, тусгаарласан тухай мэдээлэл;
- 6.5.3. Тусгай зөвшөөрөл авах, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, барьцаалсан, бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 6.5.4. Компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигч, ТУЗ-ийн Дарга болон Гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл;
- 6.5.5. Компани аливаа хэлбэрээр өөрчлөн байгуулагдах, болон бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компани, эсхүл бусад этгээдэд шилжүүлсэн, эсхүл хязгаарлах болсон тухай мэдээлэл;
- 6.5.6. Шинээр үнэт цаас гаргах, компанийн хувьцааг халааслах, нэмж гаргах, нэрлэсэн үнийг өөрчлөх, хувьцааг хуваах, нэгтгэх, хөрвүүлэх нөхцөлд холбогдох шийдвэр, нөхцөлийн талаар мэдээлэл;
- 6.5.7. Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар, эсхүл бүхэлдээ зогссон нөхцөлд холбогдох мэдээлэл;

- 6.5.8. ТУЗ-өөс ногдол ашигтай холбоотой шийдвэр гаргасан тухай мэдээлэл;
- 6.5.9. Компани төлбөрийн чадваргүй болсонд тооцогдох нөхцөл үүссэн бол үүнтэй холбоотой тайлбар;
- 6.5.10. Холбогдох хуулийн дагуу татан буугдах нөхцөл бүрдсэн тохиолдолд үүнтэй холбоотой тайлбар;
- 6.5.11. Компани өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш хэмжээний дүнтэй дүйцэхүйц нэхэмжлэлд хариуцагчаар оролцох болсон үүнтэй холбоотой тайлбар;
- 6.5.12. Хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал нь гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол үүнтэй холбоотой тайлбар.
- 6.6. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-д үнэт цаасаа бүртгүүлсний дараа эрх бүхий байгууллагаас авсан барьцааны лавлагаа, баталгаа, батлан даалтыг нотлох баримт, баталгаажуулсан гэрээг Бүртгэлийн нэгжид хүргүүлэх үүрэгтэй.
- 6.7. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичигт өөрчлөлт орсон бол энэ тухай Бүртгэлийн нэгжид ажлын 1 өдрийн дотор мэдээлнэ.
- 6.8. ББЗЗ-д бүртгэлтэй Үнэт цаас гаргагч нь энэ бүлэгт заасан мэдээ, мэдээллийг Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай хамтран ажиллаж байгаа тохиолдолд өөрийн Үүргийн гүйцэтгэл хангуулагчид хүргүүлнэ. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь мэдээллийг үнэн зөв, энэ журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт хийсний дараагаар Бүртгэлийн нэгжид хүргүүлж, ББЗЗ-ийн цахим системээр дамжуулан ББЗЗ-ийн оролцогчдод ил болгоно.
- 6.9. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь энэ журмын 6.8-д заасны дагуу мэдээллийг Бүртгэлийн нэгжид хүргүүлэхдээ өөрийн дүгнэлтийг Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээ, мэдээлэлд хавсаргана. Уг дүгнэлтээр үнэт цаас гаргагчийн барьцаа, баталгаанд явцын үнэлгээ хийж, түүний үйл ажилагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд үнэлэлт өгсөн байна.
- 6.10. Үүргийн гүйцэтгэл хангуулагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь түүний санал болгосон хууль болон аудитын компанитай энэ журмын дагуу тогтмол хүлээх үүрэг, ирүүлэх мэдээллийг боловсруулах, түүнд үнэлэлт өгөх чиглэлээр хамтран ажиллаж болно.

Үнэт цаас гаргагчийг мэдээлэх үүргээс чөлөөлөх

- 6.11. Үнэт цаас гаргагч нь дараах нөхцөл, шаардлагыг хангаж байх тохиолдолд бүх үнэт цаас эзэмшигчийн зөвшөөрлийг үндэслэн энэ бүлэгт заасан тогтмол болон тухай бүр ирүүлэх мэдээллийг Бүртгэлийн нэгж болон нийт ББЗЗ-ийн мэргэжлийн оролцогчдод хүргэх үүргээс чөлөөлж болно. Үүнд:
- 6.11.1. СЗХ-оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрддөг компани, нээлттэй хувьцаат компани бол;
- 6.11.2. Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг худалдан авах хөрөнгө оруулагч нь тодорхой бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тухайн үнэт цаастай холбоотой аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр баталсан
- 6.11.3. Нийт хувьцаа эзэмшигч эсхүл Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийг худалдан авсан хөрөнгө оруулагч нь Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагчаар дамжуулан мэдээ, мэдээлэл авах тухайгаа бичгээр илэрхийлсэн бол;
- 6.11.4. Үнэт цаас гаргагч нь Засгийн газар эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсын Хөгжлийн банк бол.



- 6.12. Үнэт цаас гаргагч нь Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр энэ журмын дагуу хүлээсэн мэдээлэл ирүүлэх үүргээ гүйцэтгүүлж болох ба энэ нь түүнийг энэ журамд заасан аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7. БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

- 7.1. Бүртгэлийн хороо нь үнэт цаасыг бүртгэсэн шийдвэрт өөрчлөлт оруулах, үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэр гаргана.
- 7.2. Үнэт цаас гаргагч нь дараах тохиолдолд ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлж болно. Үүнд:
- 7.2.1. Өөрийн хүсэлтээр компанийг нэгтгэх, хувьцаа хуваах болон нэгтгэх, өрийг хувьцаагаар солих, компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах;
- 7.2.2. Төслийн танилцуулга бэлтгэснээс хөрөнгө оруулагчдад танилцуулах хүртэлх хугацаанд нийгэм, эдийн засгийн нөхцөлд байдалд үнэт цаасны нөхцөлд нөлөөлөхүйц өөрчлөлт гарсан бол (бүх нийтийг хамарсан цар тахал, эрх бүхий байгууллагын эдийн засаг, худалдаа, нийгмийн бодлого өөрчлөгдсөн, шинэ нөхцөл байдал үүссэн гэх мэт);
- 7.2.3. Үнэт цаас гаргагч нь өрийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан өрийн бичгээ зах зээлийн зарчмаар хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах замаар ББЗЗ-д бүртгүүлсэн бондын тоо ширхэгт өөрчлөлт оруулах;
- 7.2.4. Холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт орсон.
- 7.3. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
- 7.3.1. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр, үндэслэлийн хамт;
- 7.3.2. Бүртгэлд өөрчлөлт оруулснаар бий болох давуу тал, хүлээгдэж буй үр дүн, нөхцөл байдлын талаарх судалгаа;
- 7.3.3. Үнэт цаасны өгөөж, эрсдэл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, мөнгөн урсгалын төлөвлөгөөнд өөрчлөлт орох тохиолдолд шинэчилсэн санхүүгийн таамаглал, төлөвлөгөө;
- 7.3.4. Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн дүгнэлт, баталгаа;
- 7.3.5. Төслийн танилцуулгад өөрчлөлт орсон бол шинэчилсэн танилцуулга.
- 7.4. Үнэт цаас гаргагч, түүний Андеррайтер эсхүл Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг бүртгэлийн нэгжээр дамжуулан Бүртгэлийн хороонд гаргана.
- 7.5. Энэ журмын 7.4-т заасан хүсэлтийг Бүртгэлийн хороо нь ажлын 3 өдөрт багтаан Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх тухай асуудлыг энэ журмын 5-р бүлэгт заасан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ.
- 7.6. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан тохиолдолд Бүртгэлийн нэгж нь ББЗЗ-ийн цахим системд зохих өөрчлөлтийг оруулж, ББЗЗ-ийн оролцогчдод мэдээлнэ.

Үнэт цаасыг бүртгэлээс хасах

- 7.7. Бүртгэлийн хороо нь дараах тохиолдолд үнэт цаасыг ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлээс хасна. Үүнд:



- 7.7.1. Үнэт цаас гаргагч үндэслэл бүхий хүсэлт гаргасан;
- 7.7.2. Өрийн хэрэгслийн эргэн төлөлт бүрэн хийгдэх, хугацаа дууссан эсхүл Төслийн танилцуулга дээр эргүүлэн дуудах нөхцөл заасан ба түүнийг хэрэгжүүлсэн бол;
- 7.7.3. Төслийн танилцуулгад заасан хуваарьт хугацаа өнгөрснөөс хойш 3 сарын хугацаанд үнэт цаас ББЗЗ-д санал болгоогүй бол;
- 7.7.4. Бүртгэлийн хорооны шийдвэр гарснаас хойш 6 сарын хугацаанд эхний транчийн анхдагч зах зээлийн арилжаа дуусаагүй бол;
- 7.7.5. Бүртгэлийн хорооны шийдвэр гарснаас хойш 18 сарын хугацаанд бүх транчийн анхдагч зах зээлийн арилжаа дуусаагүй бол (үүнд хөтөлбөртэй бонд хамаарахгүй);
- 7.7.6. Үнэт цаас гаргагч төлбөрийн чадвар нь алдагдсан эсхүл төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон;
- 7.7.7. Татан буулгах эрх бүхий этгээдийн шийдвэр гарч түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн;
- 7.7.8. Дампуурлын хэрэг гүйцэтгэгч буюу эрх хүлээн авагч томилогдсон;
- 7.7.9. Хууль, журамд заасан бусад үндэслэлээр Бүртгэлийн нэгж нь үнэт цаас эзэмшигчдийн эрх ашиг, зах зээлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор үнэт цаасыг бүртгэлээс хасах саналыг Бүртгэлийн хороонд оруулж болно.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэл

- 7.8. Бүртгэлийн хорооноос Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэлээс хасах болон бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарсан тохиолдолд уг шийдвэрийг мэдэгдлийн хамт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

8. ШИМТГЭЛ, ХУРААМЖ

- 8.1. Бүртгэлийн нэгж нь ББЗЗ-д үнэт цаас бүртгэх, хяналт тавихад энэ журмын Хавсралт 8-д заасан шимтгэл, хураамжийг нэхэмжилнэ.
- 8.2. Удирдах зөвлөл энэ журмаар тогтоосон шимтгэл, хураамжийг тодорхой нөхцөл, хугацаатайгаар хөнгөлөх, урамшуулал зарлаж болно.
- 8.3. ББЗЗ-ийн бүртгэлд нэг жилээс бага хугацаатай үнэт цаас бүртгүүлсэн бол жилийн хураамжийг нэг жилээр тооцож нэхэмжилнэ.
- 8.4. Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан шимтгэл, хураамжийг Бүртгэлийн нэгжээс хүргүүлсэн нэхэмжлэхэд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

9. БУСАД


Сонирхлын зөрчлийг тодорхойлох

- 9.1. Бүртгэлийн хорооны гишүүн өөрөө эсхүл ажиллаж буй байгууллага нь Үнэт цаас гаргагчтай холбоо, хамаарал бүхий дараах тохиолдолд Бүртгэлийн хорооны гишүүнийг сонирхлын зөрчилтэй гэж үзнэ. Үүнд:
 - 9.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч бол;
 - 9.1.2. Компанийн тухай хуулийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээд бол;;

- 9.1.3. Үнэт цаас гаргагч этгээдийн удирдах албан тушаалтан, УЗ, ТУЗ-ийн гишүүн, нягтлан, компанид таваас дээш жил ажилласан захиргааны албан тушаалтантай төрөл, садангийн холбоотой бол;
 - 9.1.4. Үнэт цаас гаргагч этгээдтэй хамтран ажиллах, зөвлөгөө өгөх болон бусад гэрээний үндсэн дээр хамтран ажиллаад 3 жил өнгөрөөгүй байгаа бол;
 - 9.1.5. Үнэт цаас гаргагчтай сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл хийж байсан, хийхээр хэлэлцэж байгаа бол;
 - 9.1.6. Үнэт цаас гаргагчийн оролцож буй шүүх, арбитрын маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилийн дотор оролцож байсан, байгаа бол;
 - 9.1.7. Үнэт цаас гаргагч байгууллагад гурав ба түүнээс жил ажилласан эсхүл түүнд ажиллаж байгаад ажлаасаа гараад гурван жил болоогүй байгаа бол;
 - 9.1.8. Үнэт цаас гаргагч нь компани бол түүний охин, толгой, зэргэлдээ, хараат компанитай энэ журамд заасан хамаарал бүхий бол;
 - 9.1.9. Холбогдох хууль, журамд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзэж болох бусад нөхцөл байдал.
- 9.2. Бүртгэлийн хорооны гишүүн Хавсралт 6-д заасан “Сонирхлын зөрчилтэй эсэхийг шалгах хуудас”-ыг бөглөж сонирхлын зөрчил үүсэхээр нөхцөл байдлыг Холбоонд мэдэгдэх үүрэгтэй. Түүнчлэн Бүртгэлийн нэгж, Удирдах зөвлөлөөс тийм нөхцөл байдал байгаа үзвэл тухайн гишүүнийг тухайн үнэт цаасыг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах эрх, үүргээс чөлөөлж болно.
- 9.3. Энэ зүйлд заасан сонирхлын зөрчилтэй боловч Бүртгэлийн нэгж, Удирдах зөвлөлд мэдэгдэлгүй үнэт цаасыг бүртгэх эсэхийг шийдвэрлэх хуралд оролцсон бол Холбооны ёс зүйн дүрэм, холбогдох журам, Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу хариуцлага хүлээх үндэслэл болно.

Хариуцлага

- 9.4. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер, Үүргийн гүйцэтгэл хангуулагч, Хөндлөнгийн этгээдүүд нь энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд энэ журам болон бусад холбогдох хууль, журам заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 9.5. Бүртгэлийн нэгж нь үнэт цаас гаргагчийг холбогдох хууль, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагч болон холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 9.6. Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Үнэт цаас гаргагч болон Андеррайтер, Үүргийн гүйцэтгэл хангуулагч, Хөндлөнгийн этгээдүүдэд Бүртгэлийн хороо, бүртгэлийн нэгжийн саналыг үндэслэн дараах хариуцлагыг хамтад нь эсхүл тус тусад нь ногдуулна. Үүнд:
 - 9.6.1. Зөрчил дутагдлын талаар тухайн этгээдэд мэдээлэх, сануулах, албан шаардлага тавих;
 - 9.6.2. Тавьсан шаардлагыг биелүүлээгүй мөн буруутай үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Бүртгэлийн нэгж болон Үнэт цаас гаргагчийн хооронд байгуулсан гэрээний дагуу торгууль ногдуулах;
 - 9.6.3. ББЗЗ-ийн бүртгэлд үнэт цаас бүртгүүлэх, үүнтэй холбоотой мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх эрхийг 3-аас 6 сар хүртэлх хугацаагаар хязгаарлах;
 - 9.6.4. ББЗЗ-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 3-аас 6 сар хүртэлх хугацаагаар хязгаарлах;
 - 9.6.5. ББЗЗ-д үйл ажиллагаа явуулах, оролцох эрхийг түдгэлзүүлэх, шууд оролцогчоос хасах саналыг Бүртгэлийн хороонд хүргүүлэх



- 9.7. Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга энэ журмын 9.6-д заасан арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх бөгөөд 2 буюу түүнээс дээш удаа хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийг ББЗЗ-ийн бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
- 9.8. Энэхүү журамд заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл ирүүлснээс үүдэн бусдад учирсан хохирол, хариуцлагыг уг зөрчлийг гаргасан Үнэт цаас гаргагч болон түүний Үүргийн гүйцэтгэл хангуулагч хариуцна.
- 9.9. Төслийн танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг бусад хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран бие даан хариуцна.

Гомдол гаргах, шийдвэрлүүлэх

- 9.10. Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой аливаа гомдол, саналаа Бүртгэлийн хороонд гаргана.
- 9.11. Үнэт цаас гаргагч нь Бүртгэлийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрөх тохиолдолд уг шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Удирдах зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.
- 9.12. Удирдах зөвлөл нь Үнэт цаас гаргагчийн гаргасан аливаа гомдлыг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

Өрийн хэрэгслийг зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх

- 9.13. Бүртгэлийн нэгж нь Монголбанкны тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлтэй холбоотой холбогдох мэдээллийг өгнө.



Хавсралт 1. Маягт №2001

“Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ӨЗБ

Бүртгэлийн хороонд


ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

[огноо]

Бид [Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] энэхүү маягтад тусгасан үнэт цаасыг “ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү хүсэлтийг гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Оноосон нэр	
Бүртгэлтэй улс, Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Үйл ажиллагааны чиглэл	
Үүсгэн байгуулагдсан огноо	
Оршин байгаа албан ёсны хаяг	
Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас	
Хүсэлт гаргасантай холбоотой хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас	
Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл (5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ)	
Компанийн эцсийн өмчлөгч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой эрх бүхий албан тушаалтны товч мэдээлэл (овог, нэр, албан тушаал, холбоо барих мэдээлэл)	
Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл	
Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эсэх, өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо, ширхэг, код, ISIN код	



2. Үнэт цаасны мэдээлэл

Үнэт цаасны нэр	
Үнэт цаасны төрөл	
Үнэт цаасны тоо ширхэг, үнэ, үнийн дүн	
Үнэт цаасны хугацаа, хүү: (Хүүгийн хувь хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн хэрэгслийн хугацаа зэргийг бичнэ)	
Үнэт цаасны нөхцөл: (Хямдруулсан, хөрвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас өмнө эргүүлэн татах гэх мэт)	
Татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ	
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаарх товч мэдээлэл	
Үнэт цаасны барьцаа, батлан даалт баталгааны талаарх мэдээлэл	
Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ, санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон бол тус мэдээллийн талаар	
Өрийн хэрэгсэл нь даатгалын байгууллагаар даатгагдсан бол тус мэдээллийн талаар	
Үнэт цаасыг арилжихаар төлөвлөсөн хугацаа	

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл:

Андеррайтерийн оноосон нэр:	
Бүртгэлтэй улс, Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо (Нотлох баримтыг хавсаргана)	
Оршин байх албан ёсны хаяг	
Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас	
Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн оноосон нэр:	

Бүртгэлтэй улс, Улсын бүртгэлийн дугаар	МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР
Регистрийн дугаар	ТТЭЗЭГ - 00000001
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо (<i>Нотлох баримтыг хавсаргана</i>)	
Оршин байх албан ёсны хаяг	
Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас	
Аудитын компанийн оноосон нэр:	
Бүртгэлтэй улс, Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо (<i>Нотлох баримтыг хавсаргана</i>)	
Оршин байх албан ёсны хаяг	
Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас	
Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:	
Бүртгэлтэй улс, Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо (<i>Нотлох баримтыг хавсаргана</i>)	
Оршин байх албан ёсны хаяг	
Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас	
Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан бол энэ тухай мэдээлэл: (Нэр, эрхэлдэг ажил, албан тушаал, хуулийн этгээд бол хаяг байршил, боловсрол, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал зэргийг бичнэ).	

Энэхүү хүсэлт, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчдад тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны төслийн танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.



Өргөдөл гаргасан:

Овог, нэр Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....”К-ийн ТУЗ-ийн дарга (Гарын үсэг, тамга, тэмдэг)	Овог, нэр Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....”К-ийн Гүйцэтгэх захирал (Гарын үсэг, тамга, тэмдэг)
Овог, нэр Албан тушаал: Андеррайтерийн “.....”К-ийн Гүйцэтгэх захирал (Гарын үсэг, тамга, тэмдэг)	Овог, нэр Албан тушаал: ҮЦ итгэмжлэн гаргагч “.....”К-ийн Гүйцэтгэх захирал (Гарын үсэг, тамга, тэмдэг)
Овог, нэр Албан тушаал: Хуулийн зөвлөх “.....” ХХН-ийн Гүйцэтгэх захирал (Гарын үсэг, тамга, тэмдэг)	Овог, нэр Албан тушаал: Аудит “.....”К-ийн Гүйцэтгэх захирал (Гарын үсэг, тамга, тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Холбооны албан хэрэгцээнд/

Хүсэлт хүлээн авсан ажилтны овог, нэр:	Хүсэлт хүлээн авсан огноо, цаг, минут:	Хүсэлт түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:



Хавсралт 2. Маягт №2002

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭГДЭЛ

[огноо]

Үнэт цаас гаргагч компанийн мэдэгдэл

1. [Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ энэхүү мэдэгдлээр баталгаажуулж байна. Үүнд:
 - 1.1. “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ӨЗБ /цаашид “**Холбоо**” гэх/-ийн “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам” /цаашид “**ББ33-ийн үнэт цаасны бүртгэлийн журам**” гэх/ болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаас гаргаж бүртгүүлэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөв бүрдүүлсэн.
 - 1.2. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой “ББ33-ийн үнэт цаасны бүртгэлийн журам”-д тусгагдсан Үнэт цаас гаргагч болон төслийн танилцуулгын нөхцөл шаардлагыг бүрэн хангасан.
 - 1.3. “ББ33-ийн үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан болон холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шаардагдах бусад мэдээллийг хүсэлтийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй эсхүл мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг нөхөж тусган, залруулж хүргүүлнэ.
 - 1.4. Үнэт цаас бүртгүүлэх зөвшөөрөл авахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн хүсэлтэд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх баримт материал байх тохиолдолд Бүртгэлийн хороонд нэн даруй мэдээлнэ.
 - 1.5. Худал, ташаа мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Үнэт цаас гаргагч нь ББ33-ийн цахим системд бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
 - 2.1. Манай үнэт цаас ББ33-ийн цахим системд бүртгэгдсэн нөхцөлд ББ33-ийн ерөнхий журам, ББ33-ийн үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шаардлагыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж дагаж мөрдөн ажиллана.
 - 2.2. Үнэт цаас гаргагч нь ББ33-ийн харилцаанд дагаж мөрдөгдөх холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд Үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль, дүрэм, журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

3. [Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага] миний бие Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон СЗХ, ББ33-ийн



холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллахаа үүгээр мэдэгдэж байна.

4. Дараах зүйлсийг ББЗЗ-ийн журмаар тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ:
 - 4.1. Холбооны зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг хүргүүлэх
 - 4.2. Холбооны зүгээс "ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах,
 - 4.3. Мөн өөрийн байгууллагад шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,
5. Үнэт цаас бүртгүүлэхээр хүргүүлж буй хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичигт заасан мэдээллүүд нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
6. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хүргүүлэх мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

Холбооноос үзүүлэх үйлчилгээний хөлстэй холбоотой мэдэгдэл

7. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс төгрөгийг ... оны ... дугаар сарын ...-ны өдөр..... банкны дансанд төлсөн нь үнэн болно. /Төлбөр төлсөн баримтын хуулбарыг хавсаргах/
8. Хэрэв Бүртгэлийн хороо нь хүсэлтэд тусгасан үнэт цаасыг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан тохиолдолд Үнэт цаас гаргагчийн төлсөн "Үнэт цаасны бүртгэлийн үйлчилгээний хөлс" нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
9. Удирдах зөвлөлөөс тогтоосон хувь хэмжээгээр аливаа хураамж, шимтгэлийг төлөхөө үүгээр мэдэгдэж байна

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

"....."К-ийн

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

"....."К-ийн

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

1. Үнэт цаас гаргагч компанийн үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийн маягт болон ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу шаардлагатай бүхий л баримт материалыг Бүртгэлийн хороонд хүргүүлсэн.
2. Бид хууль, журамд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулснаа мэдэгдэж байна:
 - a. Андеррайтер нь Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцөлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материалд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, материал орхигдуулаагүй болно.
 - b. Төслийн танилцуулга болон үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлттэй хамт хүргүүлж буй андеррайтерийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
 - c. А). Андеррайтер нь Үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.
Б). Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд байх тул хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг хавсаргасан болно.
 - d. Бид андеррайтерийн дүгнэлт гаргах, төслийн танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
 - e. Үнэт цаас гаргагч компанийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг хариуцан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
 - f. Үнэт цаас гаргагч компани нь бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсний дараах Үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

(Тамга/тэмдэг)



Хавсралт 4. Маягт №2004

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАГЧИЙН МЭДЭГДЭЛ

[огноо]

Бид Үүргийн гүйцэтгэл хангуулагч, түүнийг төлөөлж
.....нь байршилтай
..... компани буюу Үнэт цаас гаргагчийн үнэт
цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгоход Үнэт цаас итгэмжлэн гаргах үүрэг гүйцэтгэх
бөгөөд “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам” /цаашид “ББЗЗ-ийн үнэт
цаасны бүртгэлийн журам” гэх/-д заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

1. Үнэт цаас гаргагч компанийн үнэт цаасыг итгэмжлэн гаргахтай холбоотой гэрээ болон ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу шаардлагатай бүхий л баримт материалыг Бүртгэлийн хороонд хүргүүлсэн.
2. Бид хууль, журамд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулснаа мэдэгдэж байна. Үүнд:
 - a. Үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлттэй хамт хүргүүлж буй өөрсдийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
 - b. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь Үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт, баталгаа гаргасан.
 - c. Бид дүгнэлт гаргах, төслийн танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
 - d. Үнэт цаас гаргагч компанийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг хариуцан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
 - e. Үнэт цаас гаргагч компани нь бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсний дараах Үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.
 - f. Үнэт цаас гаргагчийн тогтмол хүлээх үүрэг, ББЗЗ-ийн оролцогчдыг мэдээллээр хангах үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавьж, үнэт цаас бүртгэлтэй байх хугацаанд ББЗЗ-д тухайн үнэт цаасыг худалдан авсан худалдан авагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор шаардлагатай хяналтыг явуулж, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Хариуцсан мэргэжилтэн

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Хавсралт 5. Маягт №2005

**ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ, ТҮҮНД ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

№	Шалгах асуудал	Илрүүлсэн нөхцөл байдал	Тайлбар, тэмдэглэл
Нэг. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт			
1.1.	Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг бүрэн эсэх		
	Албан хүсэлт ("Үнэт цаас гаргах тухай" эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргах)		
	Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл (Маягт №2001);		
	Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл (Маягт №2002);		
	Андеррайтерийн мэдэгдэл (Маягт №2003);		
	Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай хамтран ажиллах тохиолдолд түүний мэдэгдэл (Маягт №2004);		
1.2.	Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичигт заасан мэдээлэл нь холбогдох баримтаар нотлогдож байгаа эсэх;		
Хоёр. Төслийн танилцуулга			
2.1.	Төслийн танилцуулгыг холбогдох зааврын дагуу бэлтгэсэн эсэх;		
Гурав. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь журамд заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх			
3.1.	Төслийн танилцуулга нь үдэж, хавтасласан, товьёг хийсэн баримтын хэлбэртэй байх;		
3.2.	Төслийн танилцуулгын бүх хуудсыг нэг бүрчлэн дугаарлаж, Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал нь хуудас бүрийн баруун доод буланд гарын үсэг зурж, компанийн тэмдгээр баталгаажуулсан байх;		
3.3.	Төслийн танилцуулгын эхний хуудсанд хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаарх анхааруулгыг оруулсан эсэх;		
3.4.	Хөндлөнгийн этгээд болон бусад хамтран ажиллаж үйлчилгээ авч буй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хувийг хавсаргасан эсэх;		



Хавсралт 6. Маягт №2006

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС

Бүртгэлийн хорооны гишүүний нэр:

Үнэт цаас гаргагч / шууд оролцогчийн нэр:

Та үнэт цаас гаргагчтай дараах тохиолдлуудын аль нэгээр хамаарал бүхий бол өөрийгөө ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн тухайн этгээдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзана уу.

Та ✓ гэсэн тэмдэглэгээг доорх хүснэгтэд тэмдэглэн ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ шалгана уу. Амжилт хүсье.

№	Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл	Тийм	Үгүй
1	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эсхүл эцсийн өмчлөгч бол,		
2	Нэгдмэл сонирхолтой этгээд бол,		
3	Үнэт цаас гаргагч этгээдийн удирдах албан тушаалтан, УЗ, ТУЗ-ийн гишүүн, нягтлан, тухайн компанид таваас дээш жил ажилласан захиргааны албан тушаалтантай төрөл, садангийн холбоотой бол,		
4	Үнэт цаас гаргагч этгээдтэй хамтран ажиллах, зөвлөгөө өгөх болон бусад гэрээний үндсэн дээр хамтран ажиллаад 3 жил өнгөрөөгүй байгаа бол,		
5	Үнэт цаас гаргагчтай сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл хийж байсан, хийхээр хэлэлцэж байгаа бол,		
6	Үнэт цаас гаргагчийн оролцож буй шүүх, арбитрын маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилийн дотор оролцож байсан, байгаа бол,		
7	Үнэт цаас гаргагч байгууллагад гурав ба түүнээс жил ажилласан эсхүл түүнд ажиллаж байгаад ажлаасаа гараад гурван жил болоогүй байгаа бол,		
8	Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээд бол түүний охин, толгой, зэргэлдээ, хараат компанид мөн энэ удирдамжийн 4.1-д заасан аль нэг хамааралтай бол,		
9	Ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзэж болох бусад нөхцөл байдал,		

МУЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын
28-ны өдрийн 22\41 тоот тогтоолын хавсралт



Бүртгэлийн хорооны гишүүн би Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн
хүсэлтийг хянан хэлэлцэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх дор дурдсан нөхцөл байгаа тул
уг үнэт цаасыг бүртгэх ажиллагаанд оролцохоос татгалзаж байна. (Сонирхлын зөрчилтэй
байж болох нөхцөлийн тухай тодруулж бичнэ үү)

/
.....
.....
...../

Бүртгэлийн хорооны гишүүн би Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн
хүсэлтийг хянан хэлэлцэхэд ашиг сонирхлын зөрчилгүй болно.

Бүртгэлийн хорооны
гишүүн

...../...../

Гарын үсэг




Хавсралт 7. Маягт №2007

ББЗЗ-ын ХЯНАЛТЫН ТАЙЛАН, МЭДЭЭ

*Андеррайтер нь дор дурдсан тайлан, мэдээг тогтоосон хугацаанд цахим болон хэвлэмэл хэлбэрээр Холбоонд ирүүлнэ.

№	Үнэт цаас гаргагчийн үүргийн биелэлтийн талаарх тайлан, мэдээ		Тайлан, мэдээ ирүүлэх хугацаа
1	Үнэт цаасны бүртгэлийн гэрээнд заасан үүргийн биелэлт	Улирал тутам	Дараа сарын 10-ны өдрийн дотор
2	Үнэт цаас гаргагчийн тогтмол мэдээлэх үүрэг	Журамд заасны дагуу	Журамд заасан хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор
3	Үнэт цаас гаргагчийн тухай бүр мэдээлэх үүрэг	Журамд заасны дагуу тухай бүр мэдээлнэ	
4	Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланд хийсэн дүгнэлт, зөвлөмж	Улирал тутам	Дараа сарын 10-ны өдрийн дотор
5	Үнэт цаас гаргагчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдон үүсэх эрсдэлийн үнэлгээ	Улирал тутам	Дараа сарын 10-ны өдрийн дотор



Хавсралт 8. Шимтгэл, хураамж

ББ33-д үнэт цаас бүртгэхтэй холбоотой шимтгэл хураамж

№	Шимтгэл, хураамж	Үнэт цаасны төрөл	Давтамж, тооцоолол	Дүн	Нэгж
1	Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хянах үйлчилгээний хөлс	Бүх үнэт цаас	Бүртгэлийн хорооны хуралд шинээр хэлэлцүүлэх бүрт нэг удаа	1,000,000	төгрөг
			Бүртгэлийн хорооны хуралд давтан хэлэлцүүлэх бүрт нэг удаа	500,000	төгрөг
2	Бүртгэлийн хураамж	Өрийн хэрэгсэл, ХБҮЦ	Гаргаж буй үнэт цаасны үнийн дүнгээс нэг удаа, Дээд дүн 10,000,000 төгрөгөөс илүүгүй, Доод дүн 2,000,000 төгрөгөөс багагүй байна.	0.05	Хувь
		Хувьцаа, сангийн нэгж эрх,	Гаргаж буй үнэт цаасны үнийн дүнгээс нэг удаа, Дээд дүн 10,000,000 төгрөгөөс илүүгүй, Доод дүн 2,000,000 төгрөгөөс багагүй байна.	0.1	Хувь
3	Жилийн хураамж	Бүх үнэт цаас	Бүртгэлтэй байх хугацаанд хувь тэнцүүлэн жилийн эцэст нэг удаа	500,000	төгрөг



Хавсралт 9.

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

20___.___.__.

№БГ ____

Улаанбаатар хот

Энэхүү ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Экспресс тауэр 11, 01 тоот хаягт байрлах **“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО” ӨЗБ** (Регистрийн дугаар: 8049661, цаашид “МҮЦАЭХ” гэх)-ийг төлөөлж, Ерөнхий нарийн бичгийн дарга

Нөгөө талаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй Монгол Улс, хот, дүүрэг, хороо, орших **“.....” ХХК/ХК** (РД:.....), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх) нар


Бүртгэлийн хорооны оны ... сарын ...-ны өдрийн ... тоот шийдвэрийг үндэслэн дараах нөхцөлөөр байгуулав.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр Үнэт цаас гаргагч нь ББЗЗ-д бүртгэлтэй байх хугацаанд түүний хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Бирж болон Үнэт цаас гаргагчийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Талуудын хооронд үүсэх энэхүү Гэрээгээр зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, МҮЦАЭХ-ны холбогдох журам, заавраар зохицуулна.
- 1.3. Гэрээнд дурдсан нэр томъёог МҮЦАЭХ-ны ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад журамд заасан нэр томъёоны тайлбарын дагуу ойлгож хэрэглэнэ.
- 1.4. МҮЦАЭХ нь Үнэт цаас гаргагч “.....” ХХК-ийн Хавсралтад заасан нөхцөл бүхий үнэт цаасыг ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэнэ.

2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 2.1. Үнэт цаас гаргагч нь МҮЦАЭХ-д дараах хөлсийг төлнө.
 - 2.1.1. Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс: /...../ төгрөг байна.банкны тоот дансанд Компанийн нэр болон регистрийн дугаарын хамт бичнэ.
 - 2.1.2. Үнэт цаасны жилийн үйлчилгээний хөлс: Жилд /.... / төгрөг байна.
- 2.2. Гэрээний 2.1.1-т заасан үйлчилгээний хөлсийг энэхүү Гэрээг байгуулахаас өмнө Үнэт цаас гаргагч нь МҮЦАЭХ-ны дансанд шилжүүлсэн байна.



- 2.3. Гэрээний 2.1.2-т заасан төлбөрийг Үнэт цаас гаргагч ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэлтэй байх хугацаанд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан МУЦАЭХ-ны дансанд шилжүүлнэ.
- 2.4. Үнэт цаас гаргагчийн ББЗЗ-д бүртгэлтэй үнэт цаасны арилжааг зогсоосон нь жилийн үйлчилгээний хөлс төлөхгүй байх үндэслэл болохгүй.
- 2.5. Энэхүү Гэрээний 2.1-т зааснаас бусад шимтгэл хураамжийг хадгаламжийн байгууллагын журам, МУЦАЭХ-той байгуулсан гэрээнд заасны дагуу тодорхойлно.


3. МУЦАЭХ-НЫ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. МУЦАЭХ нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 3.1.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасны арилжаанд хяналт тавих, тодорхой чиглэл удирдамжийн дагуу шалгалт хийх;
- 3.1.2. Холбогдох хууль, журамд заасан шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг ББЗЗ-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас гаргуулан авах, шаардлагатай тохиолдолд Үнэт цаас гаргагчаас гаргасан аливаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх талаар тайлбар, тодруулга авах;
- 3.1.3. Холбогдох хууль, журамд заасан шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг ББЗЗ-ийн оролцогчдод ил тод болгох, үнэт цаас эзэмшигчдэд хүргүүлэх талаар Үнэт цаас гаргагчид шаардлага тавих;
- 3.1.4. Үнэт цаас гаргагчид үзүүлсэн үйлчилгээний хөлсийг энэхүү Гэрээний 2 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжилж, төлүүлэх;
- 3.1.5. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, бүртгэлийн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор холбогдох журам, гэрээнд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас итгэмжлэн гаргагчаар дамжуулан хяналт хийх, тодруулга авах;
- 3.1.6. Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн тохиолдолд эрх хэмжээнийхээ хүрээнд МУЦАЭХ-ны "Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам", "Биржийн бус зах зээлийн арилжааны багц журам" болон энэхүү Гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох;
- 3.1.7. Хууль, журамд заасан бусад эрх.

3.2. МУЦАЭХ нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.2.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн үнэт цаасны арилжааг зохих журам, зааврын дагуу зохион байгуулах;
- 3.2.2. Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр холбогдох журам, шийдвэрийн хүрээнд ББЗЗ-ийн бүртгэлтэй холбоотой асуудлаар зааварчилгаа өгөх;
- 3.2.3. Үнэт цаас гаргагчтай холбоотой МУЦАЭХ-ны журам, зааварт өөрчлөлт орсон нөхцөлд энэ талаар болон бусад шаардлагатай мэдээллийг Үнэт цаас гаргагчид өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэх;
- 3.2.4. Үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ, мэдээллийг холбогдох журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр гаргаж өгөх;



- 3.2.5. Үнэт цаас гаргагчаас олон нийт эсхүл үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэхээр ирүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.


4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Үнэт цаас гаргагч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 4.1.1. Үнэт цаас бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах тухай хүсэлт гаргах;
- 4.1.2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлаар МҮЦАЭХ-оос заавар, зөвлөмж авах;
- 4.1.3. Үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбоотой асуудлаар МҮЦАЭХ-д санал хүсэлт гаргах, журамд заасан хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;
- 4.1.4. МҮЦАЭХ-оос шийдвэрлэсэн тохиолдолд бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх;
- 4.1.5. Холбогдох журам, зааварт заасны дагуу МҮЦАЭХ-оос үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ мэдээлэл авах;
- 4.1.6. Үнэт цаас гаргагчтай холбоотой МҮЦАЭХ-оос гаргасан шийдвэрийн талаар санал, гомдлоо эрх бүхий этгээдэд гаргах.

4.2. Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 4.2.1. Аудитын байгууллагаар баталгаажуулсан хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан Үнэт цаас итгэмжлэн гаргагчаар дамжуулан ББЗЗ-ийн оролцогчдод хүргүүлэх;
- 4.2.2. ББЗЗ-ийн бүртгэлд бүртгэлтэй байх хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явуулах ба уг үүргийг биелүүлэхэд хүрэлцэхүйц эдийн болон эдийн бус хөрөнгө, нөөцтэй байх;
- 4.2.3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад заасан зориулалтын дагуу ашиглах;
- 4.2.4. ББЗЗ-ийн бүртгэлийн журамд заасан тодорхой шалгуур, шаардлагаас чөлөөлөгдсөн тохиолдолд тэдгээрийг биелүүлэх болзол, нөхцөлийг МҮЦАЭХ-оос тогтоосон хугацааны дотор хангаж, энэ талаар МҮЦАЭХ болон ББЗЗ-ийн оролцогчдод мэдээлэх;
- 4.2.5. Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулахгүй байх, өөрчлөлт оруулах тохиолдолд бүх хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авсан байх, энэ тухай МҮЦАЭХ-нд заавал мэдэгдэх;
- 4.2.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, МҮЦАЭХ-ны журам, заавруудыг дагаж мөрдөх, холбогдох хууль, журмын хүрээнд МҮЦАЭХ-оос тавьсан шаардлагыг биелүүлж ажиллах;
- 4.2.7. МҮЦАЭХ-оос холбогдох хууль, журамд заасны дагуу шаардсан мэдээ, судалгаа, тайлбар, тодруулга гаргаж өгөх, үнэт цаас худалдах замаар хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлаар тайлбар, тодруулга өгөх;



- 4.2.8. Өөрийн үнэт цаас эзэмшигчдэд шударга, тэгш хандах;
- 4.2.9. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх талаар зохих арга хэмжээ авдаг байх, мөрдөх боломжгүй зарим нөхцөл байгаа бол энэ тухай тайлбараа МҮЦАЭХ-д мэдэгдэх ба үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;
- 4.2.10. Бүртгэлтэй байх хугацаанд МҮЦАЭХ-ны "Биржийн бус зах зээлийн бүртгэлийн журам"-д заасан үнэт цаас гаргагчийн болон үнэт цаасны шалгуурыг тогтмол хангаж ажиллах;
- 4.2.11. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас итгэмжлэн гаргагчид "Биржийн бус зах зээлийн бүртгэлийн журам"-д тусгасан мэдээ, мэдээллийг заасан хугацаанд ирүүлж, ББЗЗ-ийн арилжааны платформоор дамжуулан оролцогчдод хүргүүлэх;
- 4.2.12. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний 2 дугаар зүйлд заасан хөлсийг тогтоосон хугацаанд төлөх;
- 4.2.13. МҮЦАЭХ эсхүл Үнэт цаас итгэмжлэн гаргагчийн явуулж буй хяналт, шалгалтад туслалцаа үзүүлэх.

5. ХАРИУЦЛАГА

- 5.1. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээний 4.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд МҮЦАЭХ-ны зүгээс хууль, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу үнэт цаасыг ББЗЗ-ийн бүртгэлээс хасах болон хууль, журамд заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг эрх бүхий байгууллагад тавих хүртэл арга хэмжээ авна.
- 5.2. Үнэт цаас гаргагч Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн, МҮЦАЭХ-оос тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зөрчлийн шинж чанарыг харгалзан арилжааг түр зогсоох, үнэт цаасыг нь бүртгэлээс хасах, зайлшгүй шаардлагатай гэж үзвэл үнэт цаас эзэмшигчид, ББЗЗ-ийн мэргэжлийн оролцогчид болон олон нийтэд мэдээлэх хүртэл арга хэмжээ авна.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2.7-ын холбогдох дэд заалтын дагуу мэдээлэл ирүүлэх үүргээ биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан зөрчил гаргасан бол Иргэний хуулийн 232.5-д заасны дагуу ирүүлэх ёстой байсан мэдээлэл тус бүрт 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн анзыг МҮЦАЭХ-д төлнө.
- 5.4. Үнэт цаас гаргагч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам төлбөл зохих дүнгийн 0.01 хувиар тооцож алданги төлнө.
- 5.5. Үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үнэт цаасны арилжааг зогсоох болон бусад арга хэмжээтэй холбогдон хувьцаа эзэмшигч, бусад этгээдэд учирсан хохирлыг МҮЦАЭХ хариуцахгүй.
- 5.6. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигт худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 9.14-р зүйлд заасны дагуу үнэт цаас гаргагч, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна.
- 5.7. МҮЦАЭХ аливаа хариуцлага хүлээлгэхдээ юуны түрүүнд Үнэт цаас гаргагчид эхэлж албан бичгээр мэдэгдэж, тайлбар авах, зөрчил арилгах боломжит хугацааг олгоно. Үнэт цаас гаргагч нь заасан хугацаанд тайлбар өгөөгүй, зөрчлийг арилгаагүй тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авна. МҮЦАЭХ нь үнэт цаасыг нь



бүртгэлээс хасах, үнэт цаас эзэмшигчид, ББЗЗ-ийн мэргэжлийн оролцогчдод болон олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг урьтал болгохгүй.

6. БУСАД

- 6.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, Үнэт цаас гаргагч нь МҮЦАЭХ-ны бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.
- 6.2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Үнэт цаас гаргагч МҮЦАЭХ-ны зөвшөөрөлгүйгээр Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 6.4. Энэхүү Гэрээний алт нэг заалт нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдох тохиолдолд уг заалтыг оролцуулахгүйгээр Гэрээг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлүүлэхийг талууд хүлээн зөвшөөрсөн болно.
- 6.5. Талуудын хооронд гарсан маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадахгүй тохиолдолд гэрээнээс үүссэн маргааныг шүүхээр, бүртгэл болон арилжаатай холбоотой маргааныг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд зааснаар СЗХ-ны Маргаан таслах зөвлөлд хандаж шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО” ӨЗБ-ИЙГ “.....” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ ТӨЛӨӨЛЖ

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БУЯНХИШИГ

(гарын үсэг, тэмдэг)

(гарын үсэг, тэмдэг)

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Экспресс тауэр 11, 01

Хаяг:

Утас:

Утас:

Цахим шуудан:

Цахим шуудан: